

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

№ 25/29

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн АХ-25/04 тоот дүгнэлт, ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоол болон ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь шинэ оффист нүүж ирсэнтэй холбогдуулан цаашид ашиглах боломжгүй тавилга, эд хогшлыг ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24/41 тоот тогтоолын дагуу акталж, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулж байгааг дурдсугай.
2. Уг үйл ажиллагааны хүрээнд дараах үнийн дүн, тоо ширхэг бүхий тавилга, эд хогшлыг “ОНДО” ХХК-д худалдах тохиролцоонд хүрээд буйг тэмдэглэсүгэй.

Д/д	Хөрөнгийн төрөл	Анхны орлог	Үлдэх өртөг	Ашиглаж эхэлсэн огноо	Борлуулах үнэ
1	Буйдан	3,828,000.00	0.00	10/1/2021	800,000.00
2	Сандал гал тогоо	160,000.00	0.00	3/1/2019	50,000.00
3	Сандал гал тогоо	160,000.00	0.00	3/1/2019	50,000.00
4	Бичгийн ширээ 4 хүний	2,213,880.00	0.00	3/1/2021	1,100,000.00
5	Бичгийн ширээ – 4 хүний	2,213,880.00	0.00	3/1/2021	1,100,000.00
		8,575,760.00	0.00		3,100,000.00

3. “ОНДО” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

